



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
ХУЖИРТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 24 өдөр

Дугаар А/161

Хужирт сум

Газар эзэмших эрх шинээр олгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.16, Газрын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.2, Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 10 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Газар өмчлүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах дуудлага худалдаа явуулах журам”-ын 11.4 дэх заалт, Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны “Сумын газар зохион байгуулалтын 2023 оны төлөвлөгөө батлах тухай” 8/11/4 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын 2 дугаар багийн нутаг Бургасны Улаан хадны шилд байрлах 420 м.квд газрыг Улаанбаатар, Сүхбаатар 8 дугаар хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр, 8 давхар тоот хаягт байрлах “Юни трансмишн нэтворк” ХХК (РД:6453473)-д холбоо, мэдээлэл дамжуулах, хүлээн авах станц, шугамын зориулалтаар (30 жил)-ийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.

2. Газар эзэмших гэрээ байгуулан төлбөрийг улирал бүр тооцон хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Нямдорж)-д даалгасугай.

3. Захирамж гарсанаас хойш 90 хоногийн дотор байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, түүх археологийн судалгаа хийлгэхийг “Юни трансмишн нэтворк” ХХК (РД:6453473)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Т.БАЯРМӨНХ

622301123

D:Alban bichig;Zahiramj 2023